



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/81

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, 19.1.5, 19.1.6 дахь заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 дугаар хамтарсан тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн арга хэмжээний зардалд 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Уг зардлыг Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.
3. Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН